**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/20 Улаанбаатар хот

Хачгаар дамжих халдварт өвчнөөс
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай“ 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын даргын А/51 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Хачгаар дамжих халдварын эрсдлийг бууруулах, идэвхжлийн үеийг угтуулан тус өвчний сэжигтэй тохиолдлыг оношлох, хянах, урьдчилан сэргийлэх ажлыг 2019 оны 04 сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд эрчимтэй зохион байгуулж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д.Мажигсүрэн/-д даалгасугай.

Хоёр. Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” А/160 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт болох “Хачгаар дамжих халдварт өвчний хяналт сэргийлэлтийн” заавры дагуу сэжигтэй тохиолдлын үед шаардагдах эм урвалж, халдваргүйжүүлэх бодис, сорьц авах, тээвэрлэх хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч /Д.Мажигсүрэн/, Эмийн сангийн эрхлэгч /Н. Оюунчимэг/ нарт үүрэг болгосугай.

Гурав. Хачгаар дамжин халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд болон эмнэлгийн ажилтнуудад зориулсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж явуулахыг Халдвар судлаач /Г.Цацралтуяа/, НЭМАжилтан /Г.Соёл-эрдэнэ/ нарт даал-гасугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг улирал бүрийн эцэст тайлагнахыг Чанарын албаны дарга /Ц.Жавзан-Орлом/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЭМЧ Д.БААСТ

D: Erunkhii emchiin tushaal